



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2018/7



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2018 оны 07 дугаар сарын байдлаар)

### Нэг. Нийгмийн үзүүлэлт



#### 1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 07 сард 789 эх амаржиж, 792 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 66(9.1%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 65(8.9%)-аар, 234 хүн нас барсан нь 24(11.4%)-өөр тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 558 болж өмнөх оны мөн үеэс 41(7.9%)-ээр өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 11.7, нас баралт 3.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.5 пунктээр өсч, нас баралт 0.2 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 07 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 11 байгаа нь өмнөх оны мөн үеэс 5-аар илүү юм.



#### 1.2 Эрүүл мэнд

2018 оны 07 сарын байдлаар 201.6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар, 10.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 7.4 хувиар тус тус өсч, 6.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурчээ.


2018 оны 07 сард 921 эх жирэмсний хяналтанд орсны 87.8 хувь буюу 809 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өссөн байна.



Түргэн тусламжийн дуудлага 11.8 мянган удаа гарсны 2.0 мянга буюу 16.9 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 4.4 хувиар, алсын дуудлага өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Он гарсаар ослын улмаас 1829 хүн бэртэж, 53 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 227(14.2%)-оор нэмэгдэж, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 05 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд цусны эргэлтийн тогтолцооны өвчин 25.6 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 22.6 хувь, хавдар 20,5 хувь, хоол шингээх эрхтний өвчин 11,5 хувь, , бусад төрлийн өвчин 12.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 432 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 64(12.9%)-өөр буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 28.6 хувиар, бусад төрлийн өвчин 61.0 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




### 1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 07 сарын эцэст 663 болсны 656 (98.9%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 7 (1.1%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 1000 (39.7 %) хүнээр буурч, өмнөх сараас 263(28.4%) хүнээр буурсан байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 308 (46.5%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 298 (44.9%) нь Сайншанд суманд, 127 (19.2%) нь Замын-Үүд суманд байна.

Боловсролын түвшинг харахад 64.7 хувь нь бүрэн дунд, 14.9 хувь нь дээд, 7.4 хувь нь бүрэн бус дунд, 5.3 хувь нь техник болон мэргэжлийн, 4.2 хувь нь тусгай дунд, 2.6 хувь нь боловсролгүй, 0.9 хувь нь бага боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 07-р сард



Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 1391 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 233 иргэн ажилд зуучлагдан орж, 296 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 329 ажлын байрны 42 (12.7%) нь үйлчилгээний, 46 (13.9%) нь төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, 72 (21.9%) нь бусад салбарын, 133 (40.4%) нь уул уурхайн олборлолтын салбарын захиалга байна. Ажил хайгч 233 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 98 (42.1%) нь эмэгтэйчүүд байна

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон салбараар






#### 1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 07 сард 18773.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2600.7(16.1%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 07 сард өмнөх оны мөн үеэс 2600.7 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2125.0(21.9%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 353.4(22.1%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 240.7(21.9%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 07 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 25885.1 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 3331.2 (14.8%) сая төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 18697.2(72.2%) сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 3888.6(15.0%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1438.0(5.6%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1416.0(5.5%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 445.3(1.7%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг







Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 07 сард нийгмийн халамжийн сангаас 22184 иргэнд 4668.3 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 5930 (36.5%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 1515.9 (48.1%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд цалинтай ээж хөтөлбөрт 3653 иргэнд 1013.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1340 хүн хамрагдсан нь өмнөх оноос 37 (2.8%)-ээр, олгосон тэтгэвэрийн хэмжээ 458.3 (53.9%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 1056 иргэнд 436.7 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 975 иргэнд 349.2 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 7819 иргэнд хамруулж 460.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 10994 иргэнд 2113.8 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/





## 1.5 Гэмт хэрэг


Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 07 сарын байдлаар 329 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 76 хүн гэмтэж, 12 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 54(14.1%)-өөр, нас барсан хүний тоо 4(25.0%)-өөр, гэмтсэн хүний тоо 42(35.6%) -оор буурсан байна.

Төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 9-өөр нэмэгдэж бусад төрлийн гэмт хэрэг буурчээ.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 42.9 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 24.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 9.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчсөн гэмт хэрэг, 4.9 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэргүүд эзэлж байна. Сogтуугаар үйлдсэн гэмт хэрэг 33 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75(69.4%) -аар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Дэлгэрэх, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурч, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 585.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2441.3 (80.6) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 340.0 (58.1%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 95 (28.9%) нь гэр сууцандаа, 42(12.8%) нь гудамж олон нийтийн газарт, 33 (10.0%) нь согтуугаар, 37 (11.2%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 16 (4.9%) бүлэглэн, 115 (35.0%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 773 хүн эрүүлжүүлэгдэж, 161 хүн баривчлагджээ.



Зураг. Бүртгээгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 07 сар




### Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




#### 2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 823.3 тэрбум төгрөг болж өмнөх оноос 183.2(28.6%) тэрбум төгрөгөөр, цэвэр зарлага 778.1 тэрбум төгрөг болж 165.9(27.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017-2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 93.6 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1282.2 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1372.4 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 6.8 (10.3%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 23.4 (33.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 07 дугаар сарын эцэст 2940.4 сая төгрөг болж, өмнөх сараас 1041.4(54.8%) сая, өмнөх оны мөн үеэс 67.3 (2.3%) сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.3 хувийг эзэлж, өмнөх сараас 0.5 пунктээр нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 07 дугаар сарын эцэст 8426.2 сая төгрөг болж өмнөх сараас 207.6(2.5%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 404.0 (4.6%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 3.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.1 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.07 сард



Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.07 сард






## 2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 07 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 15851.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 100.8 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 30.0 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 75.5 хувийг татварын, 24.5 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 07-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 3039.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 576.1 (23.4%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 1171.4 (62.7%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



## 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2018 оны 07 дугаар сард өмнөх сараас 0.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар тус тус өсчээ.

**Ерөнхий индекс өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд:** хүнсний бараа, ундаа усны бүлэг 0.3 хувь, орон сууц, ус, цахилааны, түлшний бүлэг 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 0.7 хувь, эм, тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 0.8 хувь, тээвэр 1.6 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 0.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 1.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 07 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 07 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



## Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



### 3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 07 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 71.4 хувь буюу 604.0 мянган толгой мал төллөж, төл бойжилт 97.5 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 33.9(5.9%) мянган толгойгоор, төл бойжилт 20.7(3.6%) мянган толгойгоор илүү юм.

Эхний 7-н сарын байдлаар 8617 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 6.5(4.1 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд Дэлгэрэх, Иххэт сумдын нутаг дэвсгэрээр 4-р сард нойтон цас орж, хүчтэй цасан шуурга шуурч байгалийн онц аюултай



үзэгдэл болж, Дэлгэрэх суманд 2.2 мянган толгой мал, Иххэт суманд 2.2 мянган толгой мал, Даланжаргалан суманд 1.2 мянган толгой мал хорогдсон нь голлон нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 07-р сард ноолуурын дундаж үнэ 70000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 10000 (16.7%) төг-өөр нэмэгдсэн байна. Харин адууны шир 10.0 мянган төгрөгийн ханштай байна. Эр хонь 100.0-180.0 мян.төг, эр ямаа 80.0-150.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.

Эхний 7 сарын байдлаар 78.6 га талбайд төмс, хүнсний ногоо тариалснаас төмс 22.6 га-д, хүнсний ногоо 56.0 га-д тариалжээ. Тариалалтыг өнгөрсөн оны энэ үетэй харьцуулахад төмс тариалсан талбай 0.2 га-гаар бага, хүнсний ногооны талбай 9.1 га-гаар их байна.



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 07 сард аж үйлдвэрийн салбарт 112480.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 152806.2 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 52502.6(87.5%) сая төгрөгөөр, борлуулалт 46574.6(43.8%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2018 оны эхний 7 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 87.5 хувиар өсөхөд уул, уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 12650.1 сая төгрөгөөр, боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 39614.1 сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.7 хувийг төрийн, 96.3 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.7 хувь, компани 96.0 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал дулаан 4.0 мян.ккал-аар, сувагжуулалт 66.1 мян.м3-ээр, нарийн боов 10.9 тонноор, бялуу 0.2 тонноор, нүүрс 80.7 мян.тонноор, вакуум цонх 696.6 м2-аар, цемент 230.5 мян.тонноор, модон эдлэл 24152.8 мян.төгрөгөөр, дээл 119 ширхэгээр, жижиг оёдол 6465.6 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 07 дугаар сарын дундаж агаарын температур Улаанбадрах, Хатанбулаг сумдад 26.1-26.2 хэм дулаан, бусад сумдын нутгаар 22.6-25.1 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө 34-37 хэм дулаан байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Алтанширээ, Улаан-Уул, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад ОЖД-ийн орчим, бусад сумдын нутгаар ОЖД-аас дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 7-15 хэм дулаан, өдөртөө нийт нутгаар 59-63 хэм дулаан байв.



07 дугаар сард нийт сумдын нутгаар 8-14 өдөр бороо орлоо. Сарын нийлбэр хамгийн их бороо Өргөн суманд 100.1 мм, Хатанбулаг суманд 98.3 мм, Замын-Үүд суманд 88.0 мм, бусад сумдын нутгаар 29.6-73.3 мм бороо орлоо.

Энэ сард салхины хамгийн их хурд Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад 23-25 м/с, Айраг, Мандах, Дэлгэрэх, Улаанбадрах сумдад 16-20 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд, Замын-Үүд сумдад 22-23, Мандах, Дэлгэрэх, Хөвсгөл, Эрдэнэ сумдад 15-18, бусад сумдын нутгаар 2-10 өдөр байлаа.



## АГУУЛГА

### II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

#### Нэг. Эрүүл мэнд

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

#### Хоёр. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 2.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
- 2.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 2.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 2.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 2.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар

#### Гурав. Нийгмийн даатгал, халамж

- 3.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 3.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 3.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

#### Дөрөв. Гэмт хэрэг

- 4.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 4.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

#### Тав. Мөнгө, зээл

- 5.1 Мөнгөн гүйлгээ, зээл
- 5.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст

#### Зургаа. Орон нутгийн төсөв

- 6.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 6.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 6.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 6.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

#### Долоо. Үнэ

- 7.1 Хэрэглээний үнийн индекс
- 7.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 7.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

#### Найм. Хөдөө аж ахуй

- 8.1 Мал төллөлт, төл бойжилт
- 8.2 Том малын зүй бус хорогдол
- 8.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
- 8.4 Малын үнийн судалгаа, сумаар
- 8.5 Тариалсан талбай, сумаар, сарын эцэст

#### Ес. Аж үйлдвэр

- 9.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 9.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 9.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 9.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

#### Арав. Байгаль орчин

- 10.1 Цаг уурын үзүүлэлт

#### Тэмдэглэлийн тайлбар :

- ( ,, ) - тухайн тоо, баримт байхгүй
- ( 0 ) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- ( х ) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- ( . ) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2018 ОНЫ 07 ДУГААР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.5	0.3	100.4
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	911	856	727	792	65	108.9
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	171	179	210	234	24	111.4
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	740	677	517	558	41	107.9
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	10	9	5	8	3	160.0
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	10.5	6.9	10.1	3.2	146.9
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	568	1427	496	342	-154	69.0
- 10000 хүнд ногдох	тоо	17.9	54	73	50	-23	69.0
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 141	1 060	1 663	663	-1 000	39.9
- Үүнээс эмэгтэй	тоо	641	560	821	308	- 513	37.5
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	29	25	38	15	- 23	39.9
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	363	281	243	176	-67	72.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	363	169	243	76	-167	31.3
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	112	0	100	100	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	354	392	383	329	-54	85.9
- 10000 хүнд ногдох ***	тоо	85	92	89	76	-13	85.4
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	495055	466863	571231	591946	20715	104
- Унага	толгой	5227	5931	6342	6512	170	103
- Тугал	толгой	14239	11609	18331	19003	672	104
- Ботго	толгой	13384	11729	13737	15858	2121	115
- Хурга	толгой	237702	236137	283809	292632	8823	103
- Ишиг	толгой	224503	201457	249012	257941	8929	104
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	5964.6	8690.7	59978.2	112480.8	52502.6	187.5
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	5561.0	5596.7	106231.2	152806.2	46575.0	143.8

\* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 07 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VII	2018 I-VII	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	199.2	201.6	2.4	101.2
2. Ор хоног	мян.хүн	67.5	73.0	5.5	108.1
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	6.6	6.5	-0.1	98.5
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	9.5	10.2	0.7	107.4
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	11.3	11.8	0.5	104.4
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2	2	0	100.0
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1602	1829	227	114.2
Үүнээс: нас баралт	хүн	53	53	0	100.0
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	913	921	8	100.9
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	792	809	17	102.1
8. Амаржсан эх	хүн	723	789	66	109.1
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	3	2	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	6	11	5	183.3

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 07 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүртэл насны эндсэн хүүхэд
тоо					
Дүн	789	0	792	11	3
Айраг					
Алтанширээ	1				
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	1		1		1
Эрдэнэ	3		3	1	
Сайншанд	634		636	6	
Замын - Үүд	147		149	3	2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 07 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-VII	2017 I-VII	Өсөлт	
	Тоо			Хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	496	432	-64	87.1
Вируст гепатит	7	5	-2	71.4
Сүрьеэ	54	58	4	107.4
Тэмбүү	62	65	3	104.8
Заг хүйтэн	75	119	44	158.7
Трихоминиаз	48	51	3	106.3
Цусан суулга	19	44	25	231.6
Бусад	231	90	-141	39.0

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

342

90



*Нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулга*  
**ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

2.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 07 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015 VII	2016 VII	2017 VII	2018. VII	$\frac{2018. VII}{2015. VII}$	$\frac{2018. VII}{2017. VII}$
	хүний тоо				хувь	
ДҮН	1 141	1 060	1 663	663	58.1	39.9
Үүнээс: Эмэгтэй	641	560	821	308	48.0	37.5
Магистр, доктор	6	11	8	0	0.0	0.0
Дээд боловсролтой	281	272	379	99	35.2	26.1
Тусгай дунд	142	122	153	28	19.7	18.3
Техник мэргэжлийн	119	124	158	35	29.4	22.2
Бүрэн дунд	398	369	751	429	107.8	57.1
Бүрэн бус дунд	145	129	170	49	33.8	28.8
Бага	38	24	24	6	15.8	25.0
Боловсролгүй	12	9	20	17	141.7	2.2 <sup>2</sup>

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 07 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017. VII	2018. VII	2017. VII	2018. VII	2017. VII	2018. VII
ДҮН	1663	663	203	233	393	1391
Айраг	117	56	31	16	36	110
Алтанширээ	19	32	4	8	13	62
Даланжаргалан	73	15	8	21	20	57
Дэлгэрэх	22	20	12	4	13	16
Иххэт	32	24	0	18	11	64
Мандах	66	16	9	40	0	72
Өргөн	74	12	23	19	68	50
Сайхандулаан	38	15	4	4	12	26
Улаанбадрах	24	13	3	34	21	66
Хатанбулаг	41	8	4	0	8	40
Хөвсгөл	23	1	15	10	16	20
Эрдэнэ	32	26	4	3	13	39
Сайншанд	814	298	54	39	126	549
Замын - Үүд	288	127	32	17	36	220

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 07 сарын эцэст

Салбарын ангилал	2017.VII	2018.VII
	ТОО	
Бүгд	305	329
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	10	7
Уул уурхай олборлох аж үйлдвэр	143	133
Боловсруулах үйлдвэрлэл	9	3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт		4
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		7
Барилга	1	16
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ		1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		1
Мэдээлэл, холбоо	1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	3	13
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа		2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	39	46
Боловсрол	21	12
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	15	24
Урлаг, үзвэр,тоглоом наадам	7	9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	56	42
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		1

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 07 сарын эцэст

Үзүүлэлт	2017. VII	2018. VII
	ТОО	
Бүгд	305	329
Менежер	10	2
Мэргэжилтэн	80	85
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	38	35
Контор, үйлчилгээний ажилтан	12	11
Худалдаа, үйлчилгээний ажилтан	42	33
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	3
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	29	21
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	62	57
Энгийн ажил мэргэжил	28	72
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	10

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

## 2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 07 сарын эцэст

Үзүүлэлт	2017. VII		2018. VII	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	203	95	233	98
Менежер	9	2	2	2
Мэргэжилтэн	28	22	43	27
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	23	18	21	14
Контор, үйлчилгээний ажилтан	9	8	13	8
Худалдаа, үйлчилгээний ажилтан	34	23	28	18
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0	1	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	14	2	13	3
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	53	6	40	10
Энгийн ажил мэргэжил	29	13	63	12
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	3	1	9	4

## 2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 07 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	176	63	76	100
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2		2	
Уул уурхай олборлолт	38	12	20	18
Боловсруулах үйлдвэрлэл	4	1	2	2
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	42	9	31	11
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	8	6	8	
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	25	10	1	24
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16	13		16
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа				
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10	2	5	5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	27	7	3	24
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2	2	2	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1		1	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

## 3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 07 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-VII
	2017 I-VII	2018 I-VII	2017 I-VII
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	16 172.4	18 773.1	116.1
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	9 685.3	11 810.3	121.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 097.4	1 338.1	121.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3 346.3	3 128.9	93.5
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	1 601.3	1 954.7	122.1
Ажилгүйдлийн даатгалын сангийн	442.1	541.1	122.4
Нийгмийн даатгалын сангийн зарлага	22 553.9	25885.1	114.8
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	15 999.9	18 697.2	116.9
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 197.2	1 438.0	120.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3 581.7	3 888.6	108.6
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 217.1	1 416.0	116.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	558.0	445.3	79.8

\*\* - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

## 3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 07 сарын эцэст

Үзүүлэлт	хэмжих нэгж	2017 I-VII	2018 I-VII	2018 I-VII 2017 I-VII
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	15441	16227	105.1
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	7495	8234	109.9
Төсөвт байгууллага	тоо	7946	7993	100.6
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	16462.4	19170.9	116.5
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	12044.7	13915.5	115.5
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	1785.2	2158.8	120.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	831.7	955.2	114.8
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	498.0	508.0	102.0
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1302.8	1633.4	125.4

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



## 3.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 07 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I-VII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I-VII
	2017 I-VII	2018 I-VII	2017I-VII	2017 I-VII	2018 I-VII	2017 I-VII
	тоо	тоо	хувь	мянган төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>16254</b>	<b>22184</b>	<b>136.5</b>	<b>3152419.6</b>	<b>4668291.4</b>	<b>148.1</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1303</b>	<b>1340</b>	<b>102.8</b>	<b>849803.1</b>	<b>1308091.6</b>	<b>153.9</b>
Ахмад настны тэтгэвэр	53	59	111.3	42010.4	57951.3	137.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1250	1281	102.5	807792.7	1250140.3	154.8
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1146</b>	<b>1056</b>	<b>92.1</b>	<b>399710.3</b>	<b>436696.0</b>	<b>109.3</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1068	994	93.1	373516.4	409086.8	109.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	51	50	98.0	19866.7	23452.3	118.0
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	6	85.7	1896.5	2764.0	145.7
Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэн	11	5	45.5	3285.1	1328.9	40.5
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	1145.6	64.0	5.6
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>998</b>	<b>975</b>	<b>97.7</b>	<b>330190.0</b>	<b>349179.5</b>	<b>105.8</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	362	234	64.6	193928.4	220039.5	113.5
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	595	703	118.2	127061.6	79980.0	62.9
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	10	10 <sup>2</sup>	2000.0	20000.0	10 <sup>2</sup>
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	9	4 <sup>2</sup>	2400.0	10800.0	4 <sup>2</sup>
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	7	7 <sup>2</sup>	1200.0	8400.0	7 <sup>2</sup>
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		8			9600.0	
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>						
<b>5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал</b>	<b>5946</b>	<b>7819</b>	<b>131.5</b>	<b>557499.5</b>	<b>460516.3</b>	<b>82.6</b>
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3677	3499	95.2	162806.8	105552.5	64.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	159	182	114.5	27705.6	31180.3	112.5
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		2896	0.0		173888.0	
Банкны шимтгэл					1879.4	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	2110	1242	58.9	366987.1	142890.8	38.9
